

ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

2019

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЛБАРЫН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ, ШИЙДВЭРЛЭХ
АСУУДЛУУД



Тур оператор
компаниуд



Түүвэр
судалгаа



Гадаад жуулчид



Мэндчилгээ

Монголбанкны Аялал жуулчлалын хөгжлийн төвтэй хамтран боловсруулсан “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд” түүвэр судалгааны үр дүнгийн тайланг Эрхэм Танд өргөн барьж байна.

Монгол Улс нь өргөн уудам газар нутагтай, байгалийн болон соёлын өвийн хосгүй цогцолбор бүхий газруудаар баялаг орон билээ. Манай орны хувьд аялал жуулчлалын салбар 2018 оны байдлаар эдийн засагт 461 сая ам.долларын буюу ДНБ-ий 4 орчим хувьтай тэнцэх орлогыг бүрдүүлж, нийт 54 мянган ажлын байрыг дотоодод бий болгож байна.

Аливаа орны эдийн засгийн хөгжилд хүргэх бодлогын жор нь өөрийн онцлог давуу талд суурилсан салбарыг хөгжүүлж тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох явдал юм. Уул уурхайн салбараас өндөр хамааралтай манай улсын хувьд олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох улмаар валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг сайжруулах нь эдийн засгийн дархлааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. Аялал жуулчлалын салбар нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, түүхэн соёл, уламжлал зан заншлыг түгээх, таниулан сурталчлах, гадаад харилцааг сайжруулах зэрэг замаар эдийн засаг болон нийгмийн тогтвортой хөгжилд өндөр хувь нэмэр оруулах боломжтой салбар юм.

Салбарын хөгжлийн бодлого боловсруулахад судалгаа хийж, оролцогч талуудын санал бодлыг сонсох, түүнд үндэслэн тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, эдгээр асуудлыг шийдвэрлэх санал зөвлөмжүүдийг гаргах зайлшгүй шаардлагатай юм. Энэ утгаараа энэ удаагийн түүвэр судалгаа нь өмнө хийгдэж байгаагүй өргөн цар хүрээг хамарсан, аялал жуулчлалын салбарын эрэлт болон нийлүүлэлтийг давхар авч үзсэнээр онцлог юм. Судалгаанд 1500 гадны жуулчин, 34 тур операторуудыг хамруулж, салбарын хэмжээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын зөвлөмжүүдийг тусгалаа.

Монголбанкны зүгээс бизнесийн тогтвортой орчинг бүрдүүлэх макро эдийн засгийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал 2017 оноос хойш инфляци зорилтод түвшинд тогтворжиж, гадаад валютын нөөц нэмэгдэн, зээлийн хүү буурч, ажил эрхлэлт нэмэгдсэнээр бизнес эрхлэгчдэд үүсэх макро эдийн засгийн тогтворгүй байдлын сөрөг нөлөөллийг буурууллаа. Түүнчлэн Монголбанкны зүгээс аж ахуйн нэгжүүдийн санал бодлыг сонсох зорилгоор “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” болон “Аж ахуй нэгжүүдийн инфляцийн хүлээлт”-ийн зэрэг түүвэр судалгаануудыг тогтмол явуулж байна. Харин энэ удаагийн түүвэр судалгаагаар аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдэд түлхүү анхаарч тэдгээрт тулгамдаж буй асуудлыг тодорхойллоо.

Монголбанкн санхүү, эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдал, ирээдүйн өсөлт хөгжлийн чухал тулгуур болсон реформ, шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлэн хийх болно.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАЯРТСАЙХАН

Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд

Түүвэр судалгааны үр дүн – 2019



Энэхүү түүвэр судалгаагаар аялал, жуулчлалын салбарын хөгжил, өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээлийг эрэлт /гадаад жуулчид/, нийлүүлэлт /аялал жуулчлалын компани/ талаас тодорхойлохыг зорьсон бөгөөд уг салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчид болон салбартай холбоотой бодлого боловсруулагчдад түлхүү чиглэв.



Боловсруулсан: **Монголбанк**

Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв



Монголбанк

Бага тойруу-3, 15160

Улаанбаатар, Монгол Улс



Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв

Зайсан-9, 17023

Улаанбаатар, Монгол Улс

Энэхүү тайланд зөвхөн аялал, жуулчлалын түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэсэн тул Монголбанк болон Аялал Жуулчлалын Хөгжлийн Төвийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

2019 оны 11 дүгээр сар

Зохиогчийн эрхээр хамгаалагдсан ©2019 он. Монголбанк, АЖХТ

АГУУЛГА



БҮЛЭГ 1

Удиртгал	6
Судалгааны зорилго, ач холбогдол, аргачлал, түүвэрлэлт	6
Аялал жуулчлалын салбарын тойм	8

БҮЛЭГ 2

Гадаадын жуулчдын судалгааны үр дүн	13
-------------------------------------	----

БҮЛЭГ 3

Тур операторуудын судалгааны үр дүн	22
-------------------------------------	----

БҮЛЭГ 4

Нэгдсэн дүгнэлт	29
Зөвлөмж	30

ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1	Түүвэрлэлтийн бүтэц.....	8
Зураг 1.2	Гадаад жуулчдын тоо болон аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаний тоо (б.т).....	8
Зураг 1.3	Аялал, жуулчлалын салбарын орлого	9
Зураг 1.4	Монгол улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс (оноо болон байр)	9
Зураг 1.5	Монгол улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд, 201910	
Зураг 1.6	Гадаад жуулчдын тоо болон аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс	10
Зураг 1.7	Глобал болон аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс хоорондын хамаарал.....	11
Зураг 2.1	Насны ангилал	13
Зураг 2.2	Аяллын зорилго.....	13
Зураг 2.3	Аяллын зорилго, улсаар.....	13
Зураг 2.4	Аяллын хугацаа	14
Зураг 2.5	Аялал зохион байгуулах хэлбэр, улсаар	14
Зураг 2.6	Мэдээллийн эх сурвалж.....	14
Зураг 2.7	Мэдээллийн эх сурвалж, улсаар	14
Зураг 2.8	Мэдээлэл хуваалцах хэлбэр	15
Зураг 2.9	Зардлын задаргаа, ам.доллар.....	15
Зураг 2.10	Зардлын задаргаа, улсаар	16
Зураг 2.11	Худалдан авсан бараа, бүтээгдэхүүн.....	16
Зураг 2.12	Хийх зүйлс	16
Зураг 2.13	Монгол улсад ирэхээс өмнө тулгардаг бэрхшээлүүд	17
Зураг 2.14	Монгол улсад аялахад хамгийн их хүндрэл учруулдаг асуудлууд, хүндээс хөнгөн рүү.....	17
Зураг 2.15	Сэтгэл ханамж, ерөнхий	18
Зураг 2.16	Сэтгэл ханамж, дэлгэрэнгүй.....	18
Зураг 2.17	Монгол улсад дахин ирэх эсэх.....	19
Зураг 2.18	Хөтөч, тайлбарлагчид өгсөн үнэлгээ.....	19
Зураг 3.1	Үйл ажиллагаа явуулсан жил.....	22
Зураг 3.2	Ажиллагсадын тоо	22
Зураг 3.3	Удирдах ажилтны мэргэжил, ажилласан жил	23
Зураг 3.4	Ажилтнуудын мэдлэг, ур чадвар	23
Зураг 3.5	Үйл ажиллагааны идэвхжлийн үе.....	23
Зураг 3.6	Тур операторуудыг дэмжиж буй байгууллагууд.....	24
Зураг 3.7	Дэмжлэгүүд	24
Зураг 3.8	Тур операторуудын зах зээлд эзлэх байр суурь	25
Зураг 3.9	Санхүүжилт авах хэрэгцээ, эх үүсвэр	26
Зураг 3.10	Санхүүжилтийн тохиромжтой хугацаа	26
Зураг 3.11	Санхүүжилтийн шаардлагатай хэмжээ	26
Зураг 3.12	Жилд хүлээн авдаг жуулчдын тоо	26

БҮЛЭГ 1



1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. УДИРТГАЛ

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбар нь уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын дараа орох эдийн засгийн гуравдагч том салбар бөгөөд аялал жуулчлалын салбарын хөгжил нь бусад салбаруудтай харьцуулахад нийт эдийн засагт хамгийн их үр өгөөж үзүүлдэг гэж цөөнгүй эмпирик судалгааны ажилд дүгнэсэн байдаг. Иймд уул уурхайн салбараас өндөр хамаарал бүхий эдийн засагтай манай улсын хувьд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх улмаар валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг сайжруулах зэрэг өндөр ач холбогдолтой юм.

Мэдээллийн үнэ цэнэд суурилсан өнөөгийн ертөнцөд судалгаанд үндэслэсэн санал, зөвлөмжөөр төрийн бодлого боловсруулах нь нэн ач холбогдолтой билээ. Манай улсын аялал жуулчлалын салбарт өргөн цар хүрээтэй, бодлого боловсруулалтад дэмжлэг үзүүлэхүйц судалгааны ажил хомс байгаа тул Монголбанкнаас Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Аялал жуулчлалын хөгжлийн төв (АЖХТ)-тэй хамтран энэхүү түүвэр судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Тус судалгааны зорилго нь аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг эрэлт /гадаад жуулчид/, нийлүүлэлтийн /тур операторууд/ талаас судалж, улмаар салбарын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Судалгааны ажил нь үндсэн 4 бүлгээс бүрдэнэ. Энэхүү бүлгийн нэгдүгээр хэсэгт судалгааны ажлын ач холбогдол, аялал жуулчлалын салбарын тойм, түүвэр судалгаанд арга аргачлалын талаар авч үзлээ.

Хоёрдугаар бүлэгт түүвэр судалгаанд хамрагдсан гадаад жуулчдын сэтгэл ханамж, тулгамдаж буй асуудлыг илрүүлж, сайжруулах арга хэмжээнүүдийг тодорхойлохыг зорилоо. Дараагийн хэсэгт тур оператор компаниудын үйл ажиллагаа, санхүүжилтийн байдлыг тусган харуулахын зэрэгцээ тэдэнд ямар төрлийн байгууллагууд хэрхэн дэмжлэг үзүүлж байгааг тодорхойлж, тур операторуудыг дэмжихэд цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг нэгтгэн авч үзэв. Дөрөвдүгээр бүлэгт нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг тусгалаа.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ, ТҮҮВЭРЛЭЛТ

• Зорилго

Энэхүү түүвэр судалгааны үндсэн зорилго нь аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг эрэлт /гадаад жуулчид/, нийлүүлэлтийн /тур операторууд/ талаас судалж, салбарын бодлогын арга хэмжээний санал боловсруулалтад дэмжлэг үзүүлэхэд оршино. Энэ зорилгын хүрээнд (i) Монгол улсад ирж буй гадаадын жуулчдын сэтгэл ханамжийн түвшинг үнэлж, аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох (ii) Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй тур оператор компаниудын өнөөгийн байдал, тэдгээрийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл болон төрөөс баримталж буй бодлого, дэмжлэг хэр хүртээмжтэй байгааг тодорхойлох зорилтыг дэвшүүллээ.

• Ач холбогдол, онцлог

Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон хувийн хэвшлийн олон байгууллага байдаг ч тус салбарт өргөн цар хүрээтэй, бодлогын арга хэмжээний санал боловсруулахад дэмжлэг үзүүлэхүйц ач холбогдол бүхий түүвэр судалгааны ажил хомс байна. Монголбанкнаас “Жуулчдын зардлын түүвэр судалгаа”-г Монгол улсын

аялал жуулчлалаас олж буй орлогыг тодорхойлох, Төлбөрийн тэнцлийн статистиكت ашиглах зорилгоор 2012 оноос эхлэн 2-3 жилийн давтамжтай гүйцэтгэж ирсэн. Харин бусад байгууллагууд нэг удаагийн шинжтэй, хамрах хүрээ багатай түүвэр судалгааны ажил ¹ болон ихэнхдээ хоёрдогч тоон мэдээлэлд үндэслэсэн эмпирик судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Иймд энэ түүвэр судалгааны ажил нь аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, салбарын гол хэрэглэгчид болох гадаадын жуулчдын сэтгэл ханамж, зах зээлийн орчин, тулгамдсан асуудлуудыг бие даан судалсан анхдагч ажил болж байна. Бид судалгааны ажлын чанарыг сайжруулж, үр дүнг оновчтой тодорхойлохын тулд салбарын мэргэжлийн агентлаг болох Аялал Жуулчлалын Хөгжлийн Төвтэй хамтран гүйцэтгэсэн болно.

• Аргачлал

Монголд аялж буй жуулчдын түүвэр судалгааг гүйцэтгэхдээ тоон /анкетийн/ болон чанарын /ярилцлагын/ аргуудыг хослуулан ашигласан. Тур оператор компаниудад тулгарч буй асуудлуудыг тодорхойлохдоо Дэлхийн банкны “CAPI” системд тулгуурлан тухайн аж ахуй нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтнаас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан болно. Судалгааны санал асуулгыг бусад орнуудад хийгдсэн ижил төстэй судалгааны санал асуулгууд болон өөрийн орны онцлог дээр үндэслэн боловсруулав.

• Түүвэрлэлт

Түүврийн хамрах хүрээ нь (i) Монгол улсад аялж буй гадаадын жуулчид (ii) аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй тур оператор компаниудаас бүрдэнэ.

Гадаад жуулчдын хувьд эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг санамсаргүй түүврийн аргаар сонголоо. Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлохдоо түүврийн харьцаа болон дунджийн хувьд 95%-ийн итгэх интервалд (хамгийн багадаа 5%-ийн ач холбогдлын түвшинд) статистикийн хувьд найдвартай байх түүврийг үүсгэлээ ². Түүврийн эх олонлогийг 2018 онд Монгол Улсад аялал жуулчлалын зорилгоор ирсэн 222,165 жуулчид гэж үзсэн бөгөөд статистик тооцооллоос оновчтой түүврийн хэмжээг 1000 байхаар төлөвлөсөн боловч нийт дүнгээр төлөвлөсөн хэмжээнээс 50%-иар илүү буюу 1500 түүврийг судалгаанд хамрууллаа. Түүвэр судалгааны санал асуулгын 90 хувийг Чингис Хаан олон улсын нисэх буудлаас, үлдсэн 10 хувийг жуулчны бааз болон зочид буудлаар үйлчлүүлж буй гадаад жуулчдаас авсан.


2018 онд Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаадын

жуулчдыг улс орон, бүс нутгаар нь авч үзэхэд БНСУ-ын жуулчид 26%, ОХУ 15%, БНХАУ 14%, Япон 8%, АНУ болон Канадын жуулчид 6%-ийг тус тус эзэлж байна. Түүвэрт хамрагдсан жуулчдын хувьд харгалзан 28%, 4%, 7%, 7%, 6%-ийг эзэлж байгаагаас үзэхэд түүврийн бүтэц нь эх олонлогийг төлөөлж чадахуйц, нийцтэй тархсаныг харуулж байна.

¹ БОАЖЯ 2018 онд Аялал жуулчлалын хөдөлмөр эрхлэлтийн түүвэр судалгаа, Аялал жуулчлалын сургалтын стандартыг үнэлэх зорилго бүхий түүвэр судалгаа гүйцэтгэсэнээс өөр томоохон түүвэр судалгаа хийгдээгүй байна.

² $n = \frac{z^2 S^2 N}{\Delta^2 N + z^2 S^2}$; n-хамгийн бага түүврийн хэмжээ, z- итгэх интервалд харгалзах критик утга (95%-ийн итгэх түвшинд 1.96-тай тэнцүү байна), s- стандарт хазайлт, N- эх олонлогийн хэмжээ, Δ- үнэлгээний нарийвчлал.

Зураг 1.1 | Түүвэрлэлтийн бүтэц



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Тур операторуудын хувьд түүвэрлэлтийг сонгохдоо тэдгээрийн үйл ажиллагаа явуулсан хугацаа, жилд хүлээн авдаг жуулчдын тоог шалгуур үзүүлэлт болгон зориудын түүврээр 41 байгууллагыг ³ сонгосон бөгөөд 34 судалгааг хүчин төгөлдөр хэмээн үзэж, үр дүнг боловсруулсан болно.


1.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ТОЙМ

Аялал жуулчлалын салбар нь эдийн засгийн бусад салбаруудтай нягт уялдаатайгаар тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон эдийн засгийн бодлого хэрэгжих хамгийн боломжит салбар юм. НҮБ-ийн Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-аас 2018 онд аялал жуулчлалын үйлдвэрлэл дэлхийн ДНБ-ий 10 хувь, барааны экспортын 7 хувь, үйлчилгээний экспортын 30 хувийг тус тус эзэлж, 10 хүн тутмын нэг нь тус салбарт ажилладаг талаар мэдээлжээ. Түүнчлэн 2020 онд дэлхийн жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1,6 тэрбумд хүрэх бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо дэлхийн бусад бүсүүдээс илүү хурдацтай нэмэгдэхийг судалгаагаар тогтоосон байна.

³ АЖХолбооны мэдээлснээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 120 тур оператор байдаг.

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбар нь жар гаруй жилийн түүхтэй бөгөөд анх төрийн өмчит “Жуулчин” компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн бол өдгөө уг салбарт 1200 гаруй тур оператор компани /идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 120 гаруй/, 370 зочид буудал, 300 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, нийт 50 мянга гаруй хүн тус салбарт ажиллаж байна.


Зураг 1.2 | Гадаад жуулчдын тоо болон аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаний тоо (б.г)



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Монгол улсад аялж буй жуулчдын тоо хандлагаараа нэмэгдсээр байгаа бөгөөд 2018 онд 529,400-д хүрсэн ба тэдгээрийн дийлэнх нь БНХАУ, Орос болон БНСУ-ын жуулчид байна. Мөн БНСУ, АНУ, Австрали, Тайван, Недерланд улсын жуулчид жилд 5-11 хувиар өсч байгаа бол Япон, Герман, Франц, Их Британи зэрэг орнуудын жуулчид буурах төлөв ажиглагдаж байна.

Зураг 1.3 | Аялал, жуулчлалын салбарын орлого




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Монгол улсын аялал жуулчлалын үйлчилгээний орлого 2007 оноос эхлэн буурч 2011 онд 156 сая ам.доллар (ДНБ-ний 1.5%)-т хүрсэн хэдий ч 2011 оноос эхлэн эрчимтэйгээр өссөөр байна. Тухайлбал аялал жуулчлалын үйлчилгээний орлого 2018 онд 461 сая ам.доллар буюу ДНБ-ий 4 орчим хувьд хүрчээ /Зураг 1.3/.

• Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадвар

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ) 2007 оноос хойш 2 жил тутам 130 гаруй орны аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтийг⁴ тооцон гаргаж байна. Монгол Улс 2019 оны байдлаар энэхүү индексийн долоон онооны үзүүлэлтээс 3.50 оноог авч 93 дугаар байранд эрэмбэлэгдлээ. Энэ нь манай орны хувьд 2013 оноос хойш аваад буй хамгийн өндөр оноо бөгөөд дунджаар 9 шат урагшилсан байна. Гэвч энэхүү индексийг тооцож эхэлсэнээс хойш Монгол улс ердөө 3 орчим оноог авч ирсэн нь манай улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадвар сул байгааг илтгэж байна /Зураг 1.4/.

Зураг 1.4 | Монгол улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс (оноо болон байр)




Эх сурвалж: Дэлхийн Эдийн Засгийн Форум, 2019

Энэхүү индексийг доторх үзүүлэлтүүдээр задлан үзвэл, Монгол улс 2019 онд 2017 онтой харьцуулахад (i) Эрүүл мэнд, эрүүл ахуйн байдал /50-аас 38 дугаар байр/; (ii) Төрөөс аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх чиглэлд оруулсан байдал /102-оос 85 дугаар байр/ гэсэн 2 үзүүлэлт дээр хамгийн их ахиц гаргасан улсаар нэрлэгдлээ. Түүнчлэн аюулгүй байдал болон аялал жуулчлалын салбарын үйлчилгээний үнийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдээр харьцангуй өндөрт бичигдэж байна. Харин бизнесийн орчны үзүүлэлтээр 83-т, байгаль орчны тогтвортой байдлын үзүүлэлтээр 131-т, дэд бүтцийн хөгжлөөр 111-т, олон улсад нээлттэй байдлын үзүүлэлтээр 128-т тус тус эрэмбэлэгдэж байгаа нь манай орныг аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадвар сул орнуудын тоонд хэвээр үлдэхэд нөлөөллөө /Зураг 1.5/.

⁴ Тус индексийг тооцохдоо 4 бүлэг үзүүлэлтүүдийг хамруулан үздэг. Үүнд аялал жуулчлалын салбарын орчин, салбарыг дэмжсэн төрийн бодлого, дэд бүтэц, байгалийн болон соёлын нөөц зэрэг орно.


Зураг 1.5 | Монгол улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд, 2019



Эх сурвалж: Дэлхийн Эдийн Засгийн Форум

Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтэд ахиц гарахын хэрээр тухайн оронд ирж буй гадаад жуулчдын тоо их хэмжээгээр нэмэгддэгийг харж болно /Зураг 1.6/. Ялангуяа өрсөлдөх чадварын дунджаас дээш оноотой орнуудын хувьд энэ нөлөө нь илүү давамгайл харагдаж байна. Тухайн бүс нутгаас өрсөлдөх чадвараараа тэргүүлсэн орнуудад Испани, Япон, АНУ, Арабын Нэгдсэн Эмират Улс зэрэг багтаж байгаа бөгөөд эдгээр орнууд жилд дунджаар 20-100 сая жуулчин хүлээн авч байна. Харин Монгол улс жилд 529 мянган жуулчин хүлээн авдаг, өрсөлдөх чадвараараа дундажаас доогуур орнуудад багтаж байна.

Зураг 1.6 | Гадаад жуулчдын тоо болон аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс



Эх сурвалж: Дэлхийн Эдийн Засгийн Форум, 2019

Тухайн улс орон аялал жуулчлалын салбарын таатай орчинг хангаж чадсанаар өөрийн орны нийт эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг ⁵ сайжруулах өндөр ач холбогдолтой. Тухайлбал ДЭЗФ-аас жил бүр тодорхойлдог “Глобал өрсөлдөх чадварын индекс”⁶ болон аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс хооронд өндөр хамаарал байгааг Зураг 1.7-аас харж болохоор байна. Манай орны хувьд тус хоёр үзүүлэлтээр (тус бүр харгалзан 99, 93-т) бага орлоготой орнуудтай харьцуулахад давуу байгаа ч ижил төстэй болон бусад орлогын түвшний орнуудтай харьцуулахад өрсөлдөх чадвар нилээн сул байна.

⁵ Нэг хүнд ногдох ДНБ-ий тогтвортой өндөр өсөлтийг хангахын тулд тухайн улс орны өөрийн нөөц бололцоог удирдаж буй чадвар.

⁶ Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг тодорхойлсон тайланг Дэлхийн эдийн засгийн форумаас 2004 оноос хойш 140 улсын өрсөлдөх чадварыг 12 үндсэн бүлэг бүхий 98 үзүүлэлтээр хэмжиж байна.

Зураг 1.7 | Глобал болон аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс хоорондын хамаарал




Эх сурвалж: Дэлхийн Эдийн Засгийн Форум, 2018-2019

- **Аялал, жуулчалын салбарыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрүүд**

Монгол улсын засгийн газар болон олон улсын байгууллагуудаас аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох, олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлд цөөнгүй бодлогын арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.


Тухайлбал Монгол улсын аялал жуулчлалын салбарыг “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д эдийн засгийн тулгуур, орлогын томоохон эх сурвалж байна гэж заажээ. Энэ бодлогод тулгуурлан 2015 онд баталсан “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 2016-2025 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд салбарын дэд бүтцийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, судалгаа, мэдээллийн системийг хөгжүүлэх, чанаржуулах, салбарын хүний нөөцийг дэмжих, Монгол улсыг гадаад, дотоодод сурталчлах зэрэг зорилтуудыг тавьжээ.

БҮЛЭГ 2




ГАДААД ЖУУЛЧДЫН СУДАЛГАА


Аяллын зорилго



Сэтгэл ханамж, ерөнхий



Мэдээлэл авах эх сурвалж



Сэтгэл ханамж, дэлгэрэнгүй



2. ГАДААД ЖУУЛЧДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд нийт 1543 гадаад жуулчид хамрагдсанаас 1436 хүний санал асуулгыг хүчинтэйд тооцож шинжилгээнд ашигласан.


Тус судалгаанд нийт 55 орны жуулчид хамрагдсан бөгөөд БНСУ, АНУ, Франц, Герман, Япон, БНХАУ, ОХУ, Их Британи улсуудын жуулчид түлхүү хамрагдсан байна. Энд дурдагдаагүй бусад орнууд нийт түүврийн 2 хүрэхгүй хувь (тус бүр)-ийг эзэлж байна /Хүснэгт 1/.

Хүснэгт 1 Судалгаанд хамрагдсан улс орнууд			
№	Улс	Хүний тоо	Эзлэх хувь
1	БНСУ	402	28%
2	Бусад	271	19%
3	АНУ	173	12%
4	Франц	135	9%
5	Герман	128	9%
6	Япон	108	8%
7	БНХАУ	101	7%
8	ОХУ	63	4%
9	Англи	54	4%
Нийт		1435	100%

Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Судалгаанд хамрагдсан жуулчдын 50% нь 40-өөс дээш насныхан байгаа бол 36% нь 24-39 насны залуучууд байна /Зураг 2.1/.

Зураг 2.1 | Насны ангилал



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Судалгаанд хамрагдсан жуулчдын 72% нь Монгол улсад аялж, амрахаар, 10% нь албан ажлаар, 6% нь гэр бүл, найз нөхөддөө зочлохоор, 3% нь суралцах аяллаар, 2% нь бал сар тэмдэглэхээр ирсэн байна. Амрах, аялах зорилгоор ирсэн жуулчдын тоо ийнхүү өндөр байгаа нь тус судалгааг жуулчны улиралд явуулсантай холбоотой /Зураг 2.2/.


Зураг 2.2 | Аяллын зорилго



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Судалгаанаас харахад Франц, БНСУ-ын жуулчдын 87 орчим хувь, Герман болон АНУ-ын жуулчдын 80 орчим хувь нь аялах зорилгоор Монгол улсыг зорьсон байна. Харин Англи, БНХАУ болон ОХУ-ын иргэдийн хувьд бусад орнуудтай харьцуулахад бизнесийн журмаар түлхүү ирсэн байна /Зураг 2.3/.


Зураг 2.3 | Аяллын зорилго, улсаар



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Судалгаанд хамрагдсан жуулчдын дийлэнх буюу 76% нь 14 хүртэлх хоногийн хугацаатайгаар, үлдсэн 24% нь 14 болон түүнээс дээш хоногоор Монгол улсад байрлаж байна /**Зураг 2.4**/. Мөн үүнийг улс орноор ангилан үзвэл АНУ, Герман, Франц, Англи улсын жуулчид 7-оос дээш хоногийн хугацаатай аялж байна.


Зураг 2.4 | Аяллын хугацаа



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Нийт жуулчдын 60 гаруй хувь нь аяллаа тур агентаар дамжуулан зохион байгуулсан байна. Тухайлбал БНСУ-ын жуулчдын 77%, Франц улсын жуулчдын 69%, АНУ-ын жуулчдын 63% нь тур агентаар дамжуулан аяллаа сонгожээ. Эдгээр жуулчдын 53% нь Монголын тур оператор компанитай хамтран ажилласан байна. Харин аяллаа өөрөө зохион байгуулсан жуулчдын хувьд мөн 53% нь Монголын тур операторт хандсан байна /**Зураг 2.5**/.

Зураг 2.5 | Аялал зохион байгуулах хэлбэр, улсаар



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

2.2. МЭДЭЭЛЛИЙН ХЭЛБЭР

Монгол улсын тухай мэдээлэл авсан эх сурвалжийг тодруулан асуухад 30% нь аяллын агент, тур оператороос мэдээлэл авсан хэмээн хариулжээ. Харин үлдсэн жуулчдын 25% нь гэр бүл, найз нөхдөөсөө, 18% нь олон нийтийн сүлжээ, интернетээс мэдээлэл авсан байна /**Зураг 2.6**/.


Зураг 2.6 | Мэдээллийн эх сурвалж



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Мэдээллийн эх сурвалжуудыг голлох зах зээлийн оронтой уялдуулж харахад БНСУ, Франц улсын жуулчид аяллын агент, тур компаниар дамжуулан мэдээлэл түлхүү авдаг бол Япон улсад гэр бүл, найз нөхдийн саналыг илүүтэй сонсдог байна. Харин ОХУ, АНУ, Англи, Герман зэрэг орны жуулчид бусад орнуудтай харьцуулахад олон нийтийн сүлжээ, интернетээр дамжуулан мэдээлэл авч байна /**Зураг 2.7**/.

Зураг 2.7 | Мэдээллийн эх сурвалж, улсаар



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Монголд ирээд буцаж буй жуулчдаас мэдээллээ хэрхэн бусадтай хуваалцах талаар асуухад судалгаанд хамрагдсан жуулчдын 66% нь бусдад туршлагаа ярина гэжээ. Харин 35% нь олон нийтийн сүлжээгээр, 15% нь цахим шуудан, ил захидал явуулах байдлаар мэдээллээ хуваалцахаар байна. Аяллын цахим хуудас, олон нийтийн сүлжээг ашиглан мэдээлэл түгээж буй гадаад иргэдэд 40 хүртэлх насныхан зонхилж байна. Харин 55-аас дээш насны жуулчдын хувьд хүмүүстэй ярилцах, цахим шуудан, ил захидал илгээнэ гэжээ /*Зураг 2.8*/.

Зураг 2.8 | Мэдээлэл хуваалцах хэлбэр



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа – 2019

2.3. ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Судалгаанд хамрагдсан жуулчдын 35% нь аяллын зардлын задаргааг дэлгэрэнгүй бөглөсөн. Тус мэдээллээс харахад өөрийн орны тур агентаар дамжуулан аялал захиалсан жуулчид дунджаар **2,187** ам.доллар зарцуулж байхад Монголын тур оператороос аялал худалдан авсан жуулчид дунджаар **2,048** ам.долларыг төлдөг ажээ. Үүнд тухайн хүний худалдан авсан ноолууран эдлэл, гар урлал, бэлэг дурсгалын зүйлс багтаж байна /*Зураг 2.9*/.

Зураг 2.9 | Зардлын задаргаа, ам.доллар




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Харин аяллын багц худалдан авахгүйгээр өөрөө аяллаа зохион байгуулсан жуулчид дунджаар **1,658** ам.доллар буюу дараах байдлаар зардал гаргасан байна. Үүнд:

- тээвэрт 421 ам.доллар,
- байр сууцанд 400 ам.доллар,
- бараа, бүтээгдэхүүн худалдан авахад 319 ам.доллар,
- хоол унданд 246 ам.доллар,
- бусад үйлчилгээнд 272 ам.долларыг зарцуулжээ /*Зураг 2.9*/.

Аяллын багц худалдан авсан жуулчдын аяллын задаргааг голлох зах зээлийн орноор харахад БНСУ болон Франц улсын иргэдийн 64% нь Монголын тур агентаар дамжуулан аялсан байна. Харин Герман улсаас ирсэн жуулчид гадаадын тур агентад илүү өндөр төлбөр төлдөг ажээ. Аяллын хугацаа нь тус харьцаанд төдийлөн нөлөөгүй, жигд тархалттай байна /*Зураг 2.10*/.

Зураг 2.10 | Зардлын задаргаа, улсаар



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Тур операторын аяллыг худалдан авсан жуулчин бусад бараа бүтээгдэхүүний худалдан авалтад дунджаар 319 ам.доллар зарцуулдаг байна. Ийнхүү худалдан авалт хийхэд нийт жуулчдын 53% нь ноос, ноолууран бүтээгдэхүүн сонгосон байна.

Зураг 2.11 | Худалдан авсан бараа, бүтээгдэхүүн



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019


Мөн гар урлалын зүйлс, футболк ба бусад хувцас, гоо сайхны бүтээгдэхүүн, ном зэргийг худалдан авчээ. Тус жагсаалтад багтаагүй бусад зүйлд морин хуур, хөгжмийн CD, DVD, нум сум, шагай, шоколад, гоёл чимэглэл, Монгол цай, зөгийн бал, Чингис архи, ил захидал, морины тоног, хэрэгсэл зэргийг нэрлэжээ /Зураг 2.11/.

2.4. МОНГОЛ УЛСАД ХИЙХ ЗҮЙЛС

Жуулчид Монгол улсыг сонгон ирэхэд байгалийн унаган төрх, үзэсгэлэнт байдлыг хамгийн чухалчилж үзсэн бөгөөд дийлэнх жуулчид сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна. Үүний дараа морь унах,

гэрт байрлах, Монгол үндэсний хоол идэхийг онцолжээ. Өөрөөр хэлбэл, жуулчид Монгол соёлтой танилцахад өндөр ач холбогдол өгдөг байна.

Зураг 2.12 | Хийх зүйлс



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Аяллаас хамгийн их таалагдсан зүйлсийг асуухад гэрт байрлах, байгальд аялах, морь унах, Монгол хоол идэх зэргийг онцолжээ. Монгол улсад ирэхээс өмнө тэр бүр төсөөлөөгүй боловч маш өндөр сэтгэгдэл үлдээдэг бусад зүйлд музей, үзвэрийн газраар зочлох, ардын урлагийн тоглолт үзэх болон дэлгүүрт худалдан авалт хийхийг нэрлэсэн байна /Зураг 2.12/.

Баяр наадмыг үзсэн жуулчдын тоо харьцангуй цөөн байсан хэдий ч сэтгэгдэл өндөр байгаагаа илэрхийлсэн. Бусад жуулчдын хувьд ахин Монгол улсад ирэхдээ баяр наадмыг үзэж, адал явдалт спортыг туршина хэмээн хариулсан юм.

2.5. СЭТГЭЛ ХАНАМЖ

- Монгол улсад ирэхээс өмнө тулгардаг бэрхшээлүүд:

Монгол улсыг зорин ирсэн жуулчдын аялалдаа бэлтгэж байх үед буюу аялал эхлэхийн өмнө тулгардаг гол асуудлуудыг

индексжүүлэн хүндээс хөнгөн рүү жагсаасныг Зураг 2.13-т харуулж байна. Зургаас харахад өөрийн орны хэл дээр мэдээлэл олддоггүй, нислэгийн үнэ бусад орнуудтай харьцуулахад өндөр байдаг зэрэг бэрхшээлүүд жуулчдад хамгийн их тулгардаг байна. Харин нислэгийн захиалга хийхэд хүндрэл хамгийн бага учирдаг байна.

Зураг 2.13 | Монгол улсад ирэхээс өмнө тулгардаг бэрхшээлүүд



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Торуулбал БНСУ, БНХАУ, Япон, Герман, Франц улсын жуулчид тухайн орны хэл дээр мэдээлэл олдоц багатай гэж хариулсан бол аяллын зөвлөгөө, тайлбар, мэдээлэл дутмаг гэсэн үзүүлэлтийг улс бүрээс ирсэн жуулчид дурдсан юм.

БНСУ, Англи, Франц, Испани улсын жуулчид виз хүсэхэд хүндрэлтэй, визгүй бол дахин аялахад бэлэн гэсэн бол АНУ, Европын орнуудаас ирсэн жуулчид нислэгийн тийзийн үнэ өндөр байгааг онцолсон.

Үүнээс гадна аяллын үнэ өндөр, ганцаараа аялахад тохиромжгүй, өөрийн тээврийн хэрэгслийг оруулж ирэхэд төвөгтэй, унаа түрээслэх боломжгүй, агаарын тээврийн компани асуудалтай байдаг зэрэг хариултыг өгсөн байна.

- **Монгол улсад аялахад хамгийн таагүй, хүндрэл учруулдаг асуудлууд:**

Монголд аялахад хамгийн их хүндрэл учирсан асуудлыг эрэмбэлнэ үү гэсэн асуулгад нийт судалгаанд хамрагдагдсан жуулчдын 70 гаруй

хувь хариулсан бөгөөд хариулт бүрт жин өгч, индекс тооцож үзэхэд нийтийн ариун цэврийн өрөөний бохир, олдоцгүй байдал нь хамгийн хүндрэлтэй, таагүй сэтгэгдэл төрүүлсэн бөгөөд улс орон, нас хүйс, аяллын зорилгоос үл хамааран хүндрэлтэй санагдсан байна. Үүний дараагаар зам засвар, замын хөдөлгөөнтэй холбоотой асуудал, интернэт, утсан холбоо дутмаг зэрэг асуудлууд орсон бол аяллын хөтөлбөр, хийсэн зүйлс тааруу гэх хариулт хамгийн бага индекстэй байна /Зураг 2.14/.

Зураг 2.14 | Монгол улсад аялахад хамгийн их хүндрэл учруулдаг асуудлууд, хүндээс хөнгөн рүү



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Үүнээс гадна гэр баазын ариун цэврийн байдал, цагаан хэрэглэл, халуун ус, тог цахилгааны хүртээмж тааруу байгааг дурдсан бөгөөд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ажилтан, ажилчдын гадаад хэлний мэдлэгийг сайжруулах хэрэгтэй гэж үзсэн байна. Транзит аяллаар Улаанбаатар хотод цөөн цагийг өнгөрөөж буй жуулчдын хувьд хувийн такси, тээврийн үйлчилгээний талаар сэтгэл дундуур байгаагаа илэрхийлжээ.

Мөн дараах асуудлуудыг дурдсан байна. Үүнд:

- Аялал жуулчлалын үйлчилгээний газрууд дахь хоолны төрөл зүйл бага, цагаан хоолны сонголтгүй;
- Хөдөө замд замын тэмдэг тэмдэглэгээ, түүх соёлын дурсгалт газруудын

орчимд явган хүний зам байхгүй, байгалийн үзэсгэлэнт газарт хог хаягдал ихтэй;

- Наймаачдад мэхлүүлж, халаасны хулгайд юмаа алдсан;
- Орон нутгийн нислэгийн цагийн хуваарь, хоцорсон нислэгийн талаар мэдээлэл хангалтгүй. Мөн орон нутгийн нийтийн тээврийн хэрэгсэл хүртээмжгүй, бохир, ойлгомжгүй байсан;
- Визний төлбөр өндөр, онлайн бүртгэлийн системгүй байдаг зэрэг нь хүндрэл учруулж, сэтгэл ханамж буурахад нөлөөлсөн байна.

• Аяллын сэтгэл ханамж

Судалгаанд хамрагдсан жуулчдын 38% нь Монгол улсад өнгөрүүлсэн аялалдаа сэтгэл хангалуун, 56% нь дунд зэргийн, 5% нь хүлээлтээс доор буюу сэтгэл хангалуун бус байна гэж хариулсан байна. Харин үлдсэн 1% нь хүлээн зөвшөөрөхийн аргагүй, огт хангалтгүй гэсэн үнэлгээг өгчээ /Зураг 2.15/.

Зураг 2.15 | Сэтгэл ханамж, ерөнхий



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Монгол улсад зорин очсон газартаа /destination/ 2 хүн тутмын 1 нь маш сайн гэсэн үнэлгээ өгсөн бол тээврийн хэрэгсэл, авто замын байдлын талаар үнэлгээ өгөхдөө 3 хүн тутмын нэг нь хүлээлтээс доор байсан гэж хариулжээ. Монгол улсад аялж байгаа 10 хүн тутмын нэг нь аюулгүй байдалдаа санаа зовниж байсан бөгөөд байр сууцны чанар, стандартад сэтгэл дундуур үлдсэн байна /Зураг 2.16/.

Зураг 2.16 | Сэтгэл ханамж, дэлгэрэнгүй



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

• Сэтгэгдэл үлдээсэн зүйлс

Хүснэгт 2 | Сэтгэгдэл үлдээсэн зүйлс

1	Үзэсгэлэнт байгалиар аялах. Үүнд: хөдөө нутаг, Говь, Хөвсгөл, элсэн манхан, тал нутаг, уудам орон зай зэрэг зүйлс хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн.
2	Монгол аж ахуй, нүүдлийн соёлтой танилцах. Ялангуяа малчин айл, нутгийн иргэдийн найрсаг харилцаа, зочломтгой занг их үнэлсэн байна. Мөн мал харах, морь унах, үнээ саах зэрэг нь их сонирхолтой байжээ.
3	Наадамд оролцож, морь уралдах, бөх барилдах, нум сумаар харвахыг харж, өөрөө харваж үзсэн нь сайхан санагдсан.
4	Өөрийн хүслээр дугуй унах, машин жолоодох, хөдөө майханд хонох, загасчлах зэрэг зүйлүүдийг хийх боломжтой байсан.
5	Монгол хүмүүсийн ур ухаан шингэсэн урлагийн бүтээл, бэлэг дурсгалын зүйлсийг чухалд үздэг гэсэн байна. Ноолууран эдлэл, торгон гоёл, үндэсний хувцас зэргийг ихээр авчээ.


Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

• Монгол улсад дахин зочлох эсэх

Судалгаанд хамрагдсан жуулчдаас дахин Монгол улсад ирэх талаар асуухад жуулчдын 50% нь 4 жилийн дотор ирнэ гэж хариулсан

бол 9% нь эргэж ирэхгүй, 26% нь мэдэхгүй байна гэсэн байна /Зураг 2.17/.

Зураг 2.17 | Монгол улсад дахин ирэх эсэх




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Мөн эдгээр жуулчдын 28% нь Монгол улсыг гэр бүл, найз нөхөд болон бусад хүмүүст заавал санал болгоно гэдгээ илэрхийлсэн байна.

Аливаа жуулчинд өндөр сэтгэгдэл төрүүлэхэд хөтөч чухал үүрэгтэй бөгөөд сайн хөтөчтэй явсан аялагчийн сэтгэл ханамж харьцангуй өндөр байдаг байна. Судалгаанд хамрагдсан жуулчдын 60 орчим хувь нь аяллын хөтөч, тайлбарлагчтай холбоотой асуулгыг бөглөсөн бөгөөд 50 орчим хувь нь сэтгэл хангалуун гэж хариулсан байна. Харин 10 хүн тутмын нэг нь аяллын хөтчийн туршлага хүлээлтээс доор байсан гэж үнэлжээ /Зураг 2.18/.

Зураг 2.18 | Хөтөч, тайлбарлагчид өгсөн үнэлгээ



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

2.6. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Тус судалгаанд хамрагдсан гадаадын жуулчдын статистик нь аяллын зорилго, насны ангилал, голлох зах зээлийн орнуудын хувьд жил бүр хилээр нэвтэрсэн жуулчдын тоонд үндэслэн гаргадаг статистиктай ойролцоо гарч байгаа нь эх олонлогтой тохирч байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч илүү нарийвчлан боловсруулсан ижил төстэй судалгаатай харьцуулан, чиг хандлагыг тогтоох нь үр дүнтэй байх болно.

Судалгааны асуулгаас дүгнэхэд **Монгол улсад зочлох гадаадын жуулчдын талаас дээш хувь нь 40-өөс дээш насныхан байна.** Үүний дотор 3 хүн тутмын нэг нь 55-аас дээш насны жуулчид байгаа нь тухайн насны хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт байгааг харуулж байна. Жуулчдын Монгол улсад өнгөрөөх хугацаанд үндэслэн Азийн зах зээлийн 55-аас дээш насны, ажлын амралтанд баригдахгүй жуулчид руу хандсан урт хугацаатай аяллын хөтөлбөр бий болгох боломж байна.

Аяллын мэдээллийн дутмаг байдал нь Монгол улсад ирэхээс өмнөх хамгийн том бэрхшээл болж байгаа бөгөөд мэдээллийг олон хэл дээр хөрвүүлж, түгээх нь чухал байна.

Судалгаанаас харахад жуулчид дунджаар **13 хоногийг** Монголд өнгөрүүлдэг бөгөөд нислэгийн тийзний үнийг оролцуулан нийт **2,318 ам.доллар зарцуулдаг** байна.

Жуулчдын зарцуулалтыг шинжилж үзэхэд **аяллын үзвэр, үйлчилгээнд хамгийн бага зардлыг зарцуулдаг боловч өндөр сэтгэл ханамжтай байдаг** тул үзвэр, үйлчилгээний газруудыг хөгжүүлэх, орлогыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих хэрэгтэй байна. Мөн жуулчид Монгол улсаас худалдан авсан бараа бүтээгдэхүүндээ тун сэтгэл хангалуун байдаг байна.

Олон улсын нислэгийн тийзийн үнэ бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа нь Монгол улсын хувьд өрсөлдөөний сул талыг бий болгож байна.

Иймд олон улсын нислэгийн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлж, тийзийн үнийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай байна. Харин дотоодын нислэгийн хувьд цаг хоцрох, нисэх цагийн тодорхойгүй байдал, нислэгийн олдоц дээр анхаарах нь зүйтэй байна.

Баруун Европын хөгжингүй улс орнуудын хувьд аялал жуулчлал өндөр хөгжсөн орнууд руу визгүй аялах нь нийтлэг болсон тул аяллын визний асуудалд ихээхэн ач холбогдол өгч байна. Жуулчид **визний төлбөр, виз хүсэх явцыг хүндрэлтэй** гэснээс гадна онлайнаар виз авах боломжийг бий болгох нь зүйтэй гэсэн санал өгчээ.

Монгол улсад аялж байгаа гадаадын жуулчдад тулгардаг хамгийн хүндрэлтэй асуудал нь нийтийн бие засах газрын олдоц, ариун цэврийн асуудал байна. Жуулчдын дайран өнгөрөх зогсолтын цэгүүдэд нийтийн бие засах газар байгуулах, тэдгээрийн бүрэн ажиллагааг хангах нь жуулчдын нийт сэтгэл ханамжид чухал нөлөө үзүүлэх нь харагдаж байна. Дэд бүтцийн хөгжил, тэр дундаа авто замын засвар, жуулчны улиралд замын хөдөлгөөний түгжрэлийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Интернет, утсан холбооны асуудалд аяллын зорилго, жуулчдын онцлогоос шалтгаалж харилцан адилгүй үнэлгээг өгсөн байна. 40 хүртэлх насны жуулчдын хувьд интернет, утсан холбоонд ихээхэн өндөр ач холбогдол өгч байгаа бол Баруун Европын жуулчид утсан холбоогүй, зэрлэг онгон байгальд байгаадаа сэтгэл хангалуун байдаг ажээ.

Жуулчдын сэтгэл ханамжийн хувьд зам тээвэр, хоолны амт чанар, сонголт ба


аюулгүй байдлыг онцолсон байна. Халаасны хулгай, таксины үйлчилгээ, зам тээврийн байдал жуулчдыг аюулгүй байдалдаа санаа зовниход хүргэж байна. Мөн **үйлчилгээний ажилтнуудын гадаад хэлний мэдлэг, үйлчилгээний чанарт анхаарах** хэрэгцээ байгааг илэрхийлсэн. Аяллын хөтөчийг сургах, дадлагажуулах шаардлагатай байгаа бөгөөд үүнээс шалтгаалж аялагчдын ерөнхий сэтгэл ханамжид нөлөөлөх боломжтой байна.

БҮЛЭГ 3




ТУР ОПЕРАТОРУУДЫН СУДАЛГАА


Жилд хүлээн авдаг жуулчдын тоо



Санхүүжилт авах хэрэгцээ, эх үүсвэр



Дэмжлэгүүд



3. ТУР ОПЕРАТОРУУДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН


3.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ, ХҮНИЙ НӨӨЦ

Судалгаанд нийт 41 тур оператор оролцсоноос 34 байгууллагын санал асуулгыг хүчин төгөлдөр хэмээн үзэж, үр дүнг боловсруулсан болно.

- **Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа, ажиллагсдын тоо**

Судалгаанд хамрагдсан тур операторуудын аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа жигд тархалттай байна. Өөрөөр хэлбэл тур операторуудын тал хувь нь 10 хүртэлх жил, үлдсэн тал хувь нь 10-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байна /*Зураг 3.1/*.

Зураг 3.1 | Үйл ажиллагаа явуулсан жил



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019


Зураг 3.2-д судалгаанд хамрагдсан тур операторуудын ажиллагсдын тоог бүлэг болгон харуулж байна. Тур операторуудын нийт ажиллагсдын тоог тогтоохдоо 2 төрлийн асуулт /*нийт болон үндсэн*/ асуусан нь салбарын онцлогоос хамаарсан болно⁷.

⁷ Аялал жуулчлалын салбар жуулчны улирлаас хамааралтай байдаг бөгөөд тээврийн үйлчилгээнд ажил гүйцэтгүүлэх гэрээг ашиглах нь түгээмэл байдаг тул бид жуулчны улиралд ажиллах нийт ажилтнуудын тоо болон жилийн турш нийгмийн даатгалд хамрагдаж ажилладаг

Судалгаанд оролцогсдын 35% нь 20 хүртэлх, 50% нь 20-50, үлдсэн 15% нь 50 болон түүнээс олон тооны ажиллагсадтай байна. Байгууллагын нийт ажилтнуудын тоо нь үйл ажиллагаа явуулсан жилээс үл хамаарч байна. Тухайлбал, 5 жил үйл ажиллагаа явуулж буй тур оператор 65 ажилтантай байхад 20 жил үйл ажиллагаа явуулж буй тур оператор 10 хүртэлх тооны ажилтантай байх тохиолдлууд байна.

Тур операторуудын нийт ажиллагсдын ердөө 19% нь нийгмийн даатгалд хамрагдсан буюу үндсэн ажилтан, үлдсэн хэсэг нь гэрээт ажилтан байгаа нь аялал жуулчлалын идэвхжилийн саруудтай холбоотой юм. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 68% нь дунджаар 1-5 ажилтанг нийгмийн даатгалд хамруулсан байна.

Зураг 3.2 | Ажиллагсдын тоо




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Судалгаанд хамрагдсан тур операторуудын удирдах ажилтны 45% нь аялал жуулчлалын чиглэлээр боловсрол эзэмшсэн бөгөөд 20 орчим хувь нь хүний нөөцийн менежмент, гадаад хэл, сэтгэл судлал зэрэг нийгмийн ШУ-ны салбарын мэргэжилтэй байна. Түүнчлэн удирдах ажилтнуудын 65% нь аялал жуулчлалын салбарт 10-аас дээш жил ажилласан туршлагатай гэж хариулжээ /*Зураг 3.3/*.

ажилтнуудын тоог харьцуулан гаргахыг зорьсон болно.


Зураг 3.3 | Удирдах ажилтны мэргэжил, ажилласан жил



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Тур операторуудын дийлэнхи нь ажиллагсадынхаа мэдлэг, ур чадварт сэтгэл хангалуун байдаг байна /Зураг 3.4/.

Зураг 3.4 | Ажилтнуудын мэдлэг, ур чадвар



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019



Хүний нөөцийг чадавхжуулах ажлын хүрээнд тур операторуудын 60 орчим хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд ажилтнууддаа сургалт, семинарыг зохион байгуулсан байна.

• Үндсэн үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан тур операторуудын 38% нь үзэсгэлэнт байгаль, нүүдлийн соёл, түүх, танин мэдэхүйн аялал зохион байгуулдаг бол үлдсэн 62% нь тусгай сонирхлын, морин аялал, адал явдалт явган аялал, хямд төсөр аялал (budget), масс аялал болон дотоодын иргэдийг гадны улсад аялуулдаг гэж хариулсан байна.

Аялал жуулчлалын салбарын улирлын онцлогоос шалтгаалан тур операторуудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хугацааг асуухад 38% нь зуны 3 сар, 62% нь 6 сарын хугацаанд жуулчдыг хүлээн авдаг гэж хариулжээ /Зураг 3.5/.

Зураг 3.5 | Үйл ажиллагааны идэвхжлийн үе



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Жуулчны улирал дууссан үед тур операторуудын 51% нь улирлын бус аялал буюу өвлийн аялал, 28% нь гадаад хэлний сургалтын үйл ажиллагаа явуулах, ирэх жилийн бэлтгэл ажлыг хангадаг гэсэн бол 21% нь сул зогсолт хийдэг байна /Зураг 3.5/.

3.2. ТУЛГАРЧ БҮЙ СААД БЭРХШЭЭЛ

Тур операторуудын хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулахад дараах саад бэрхшээлүүд тулгардаг гэж хариуллаа. Үүнд:

- Үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний стандарт муу;
- Зам тээвэр дэд бүтцийн асуудал;
- Хүний нөөцийн хүрэлцээ, чадавх сул;
- Олон улсын нислэг, тээврийн хүрэлцээгүй байдал, нислэгийн өндөр үнэ;

- v. Хууль эрх зүйн орчин, бодлогын тогтворгүй, тодорхойгүй байдал, хүнд суртал;
- vi. Эвент арга хэмжээ батлагдсан хуваарьгүй, найдваргүй байдал;
- vii. Жуулчны улиралаас шалтгаалсан сул зогсолт зэрэг асуудлуудыг хамгийн ихээр дурдлаа.

Түүнчлэн тур операторууд аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгоход гадаад, дотоодын нислэгийн билетийн олдц, үнэ, нийлүүлж буй бүтээгдэхүүний үнийн тогтворгүй байдал /жуулчны бааз, цалин хөлс г.м/ зэрэг бэрхшээлүүд ихээхэн хүндрэл учруулдаг талаар хэллээ.

Мөн тур операторууд Монгол улсыг гадаад оронд сурталчлах зорилгоор олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох хүсэлтэй байдаг ч зардал, төсвийн хүндрэл болон оролцох эрх авах боломж хомс байдлаас шалтгаалан үзэсгэлэнд оролцох нь хязгаарлагддаг байна.

3.3. ДЭМЖЛЭГ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Зураг 3.6-т тур операторуудыг үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлдэг байгууллагуудыг харуулж байна. Судалгаанд хамрагдсан тур операторуудын 37% нь төрийн бус байгууллагууд болон Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам тэдний үйл ажиллагаанд хамгийн ихээр дэмжлэг үзүүлдэг гэж хариуллаа.

Зураг 3.6 | Тур операторуудыг дэмжиж буй байгууллагууд



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Зураг 3.7-т тур операторуудад хамгийн ихээр ирдэг дэмжлэгүүд болон цаашид тэдний үйл ажиллагааг дэмжихийн тулд төрийн болон төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзсэн арга хэмжээнүүдийг харууллаа. Санал асуулгын дүнгээр тур операторуудад аялал жуулчлалын үзвэр, үйлчилгээг шинээр бий болгох, үйл ажиллагаа, үйлчилгээний стандартаар хангах, хүний нөөц бэлтгэх, чадавхжуулах, аялал жуулчлалын хөгжлийн төв байгуулж идэвхтэй үйл ажиллагаа явуулах зэрэг байдлаар хамгийн их дэмжлэг үзүүлдэг байна. Харин цаашид нэн тэргүүнд авах арга хэмжээний хувьд эрх зүйн орчинг сайжруулах, аялал жуулчлалын салбарт ажиллах хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай гэж тур операторууд хариулсан байна.

Зураг 3.7 | Дэмжлэгүүд



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Түүнчлэн нээлттэй авсан асуулгаар Монгол Улсын аялал, жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд дараах тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэсэн саналыг тур операторууд өгсөн. Үүнд:

- i. Эрх зүйн орчинг сайжруулах тэр дундаа “Аялал жуулчлалын тухай хууль”-ийг шинэчлэн найруулах; зөвшөөрөл олгох журмыг боловсронгуй болгох, салбарын нэгдсэн бодлогоор хангаж тогтвортой хэрэгжүүлэх;
- ii. Олон улсын нислэг, тээврийн хүрэлцээт байдлыг нэмэгдүүлэх;
- iii. Тур оператораас бусад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг үйлчилгээний газруудын стандартыг сайжруулах, зэрэглэл тогтоох, хэрэгжилтийг хянах;
- iv. Техник технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, чанартай авто замын сүлжээг бүрдүүлэх болон бусад холбогдох дэд бүтцийн ажлуудыг сайжруулах;
- v. Татвар төлөгч тур операторуудыг хувиараа жуулчин авдаг иргэд болон гадаадын хөрөнгө оруулалттай тур операторуудын шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах нөхцлөөр хангах;
- vi. Олон нийтийн Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн ажиллах хүчин, хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх;
- vii. Монгол улсыг гадаад оронд сурталчлах, аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэг саналуудыг өгчээ.

Түүнчлэн олон улсын нисэх шинэ онгоцны буудлыг нээхтэй холбогдуулан даацын асуудлыг хэрхэн шийдэх тал дээр тур операторууд хүний нөөц, үйлчилгээний стандартыг сайжруулах, экспресс автобусаар хангах, аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ

бий болгох, жуулчдад ойлгомжтой гарын авлага бий болгож мэдээллээр хангах, зочид буудал шинээр барих, жуулчид хүлээн авдаг үйлчилгээний салбарт хөнгөлттэй зээл өгч дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлуудыг нэн чухал гэж үзжээ.

3.4. ОРЛОГО, ЗАРДАЛ, САНХҮҮЖИЛТ

Судалгаанд хамрагдсан нийт тур операторуудын 37% нь үйл ажиллагаагаа тогтворжуулахын зэрэгцээ тэлэх боломжийг эрэлхийлж байгаа бол 33% нь хурдацтай өргөжин тэлэхийн тулд ажиллаж байна гэж хариулжээ. Харин үлдсэн 30% нь үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэхээр ажиллаж байна /*Зураг 3.8*./

Зураг 3.8 | Тур операторуудын зах зээлд эзлэх байр суурь




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

• Санхүүжилт

Нийт тур операторуудын 65%-д үйл ажиллагаагаа өргөжүүлэх буюу тогтворжуулахад санхүүжилт шаардлагатай байгаа бол 20% нь нэмэлт санхүүжилт шаардлагагүй гэж үзсэн байна /*Зураг 3.9*./

Зураг 3.9 | Санхүүжилт авах хэрэгцээ, эх үүсвэр




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Цаашид санхүүжилт авах зайлшгүй шаардлагатай байгаа гэж үзсэн тур операторуудын ихэнх нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах (62%) болон банкнаас зээл авах (12%) замаар санхүүжих хүсэлтэй байна. Харин ББСБ-аас зээл авах, гэр бүл найз нөхдөөс зээлэх, хувьцаа гаргах замаар санхүүжих төлөвлөгөөтэй тур операторууд харьцангуй цөөн буюу дунджаар 12% байна /Зураг 3.9/.

Санхүүжилт авах хүсэлтэй байгаа тур операторуудын 84% нь урт хугацааны санхүүжилт (5-аас дээш жил) шаардлагатай байгаа талаар дурдлаа /Зураг 3.10/.

Зураг 3.10 | Санхүүжилтийн тохиромжтой хугацаа




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Судалгаанд хамрагдсан тур операторуудын 50 орчим хувь нь бизнесийн үйл ажиллагаагаа тогтворжуулах, өргөжүүлэхэд 100 саяаас дээш

төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна гэж хариулжээ /Зураг 3.11/.

Зураг 3.11 | Санхүүжилтийн шаардлагатай хэмжээ




Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

• Орлого, зарлага

Нийт тур операторуудын 43% нь жилд 100 хүртэлх тооны жуулчин, 23% нь 101-300, 20% нь 301-500 жуулчин хүлээн авдаг гэсэн бол 500-аас дээш жуулчин авдаг тур операторууд 14%-ийг эзэлж байна. Түүнчлэн тур операторуудын аяллын багцын дундаж үнэ дунджаар 1,107 ам.доллар байна /Зураг 3.12/.

Зураг 3.12 | Жилд хүлээн авдаг жуулчдын тоо



Эх сурвалж: АЖ түүвэр судалгаа - 2019

Өмнөх бүлэгт дурдсанчлан жуулчид Монголын агентаар дамжуулан аяллын багц худалдан авахдаа дунджаар 2,048 ам.доллар зарцуулдаг бөгөөд энэ нь тур оператор компанийн нэгж багцийн үнээс өндөр байгаа нь аялагчид нэг болон түүнээс дээш багцийг худалдан авдаг гэж дүгнэх боломжтой байна. Мөн энэхүү 2,048 ам.долларт багцийн үнээс гадна худалдан авсан бараа бүтээгдэхүүн,

нэмэлт үзвэр, үйлчилгээний үнэ шингэсэн байна.

Тур операторуудын үйл ажиллагаа явуулахад хамгийн их хүндрэл учруулдаг зардлын төрлийг асуухад түрээсийн зардал, ажиллах хүч, цалин хөлсний зардал гэж хариулжээ. Үүний дараа баяр наадмын үнийн хөөрөгдөл, сул зогсолтын зардал, нийлүүлэгчдээс ирэх гэнэтийн үнийн өсөлт болон тээврийн зардлууд багтсан байна.

3.5. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан тур операторуудын тал хувь нь 20-50 хүртэлх тооны ажилтантай бөгөөд 19% нь нийгмийн даатгалд хамруулах боломжтой байгаа нь салбарын хүний нөөцийн бодлогыг сайжруулах нэн шаардлагатай байгааг харуулж байна. Удирдах ажилтнуудын хувьд 2 хүн тутмын нэг нь аялал жуулчлалын мэргэжилтэй бөгөөд 10 гаруй жилийн туршлагатай байна.

Судалгаанд хамрагдсан тур операторууд үзэсгэлэнт байгаль, нүүдлийн соёл, түүх, танин мэдэхүйн аялал болон бусад аяллын багцаар /дунджаар 1,100 ам.долларын үнэтэй/ жилд дунджаар 360 орчим гадаад жуулчдыг хүлээн авдаг байна.

Тур операторуудын аялал жуулчлалын идэвхитэй үйл ажиллагаа явуулж, орлого хуримтлуулах хугацаа нь дунджаар 6 сар байдаг тул жуулчны бус улиралд ихэвчлэн дараа жилийн бэлтгэл ажил болон сул зогсолт хийдэг байна. Тур операторуудын 70 орчим хувь нь үйл ажиллагаагаа тэлэх боломжийг эрэлхийлж, цаашид хурдацтай өргөжин тэлэхийн тулд ажиллаж байгаа талаар дурдлаа. Ийнхүү үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тур операторуудын 65% нь санхүүжилт шаардлагатай байгаа бөгөөд урт хугацаатай (5-аас дээш жил), 50 саяаас дээш төгрөгийн санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцлөөр авах хэрэгтэй байна.

Тур операторуудын хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулахад голчлон (i) үйлчилгээний байгууллагын үйлчилгээний стандарт хангалтгүй, (ii) хүний нөөцийн хүрэлцээ, чадавхи сул, (iii) хууль эрх зүйн орчин, бодлогын тогтворгүй байдал зэрэг асуудлууд хамгийн том хүндрэл учруулдаг байна.

Тур операторуудын үйл ажиллагаанд Төрийн бус байгууллагуудын үзүүлж буй дэмжлэг зонхилж байна. Ингэхдээ тур операторуудад аялал жуулчлалын үзвэр, үйлчилгээг шинээр бий болгох, үйл ажиллагаа, үйлчилгээний стандартаар хангах, хүний нөөц бэлтгэх, чадавхжуулах, аялал жуулчлалын хөгжлийн төв байгуулж идэвхтэй үйл ажиллагаа явуулах зэрэг байдлаар хамгийн их дэмжлэг үзүүлдэг байна.

Харин цаашид Монгол Улсын аялал, жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг нэн тэргүүнд авах шаардлагатай байна. Үүнд:

- i. Эрх зүйн орчинг сайжруулах, салбарын нэгдсэн бодлогоор хангаж тогтвортой хэрэгжүүлэх;
- ii. Хүний нөөцийг чадавхжуулж, мэргэжлийн зэрэг олгох;
- iii. Олон улсын нислэг, тээврийн хүрэлцээт байдлыг нэмэгдүүлэх;
- iv. Үйлчилгээний газруудын стандартыг сайжруулах;
- v. Дэд бүтцийн ажлыг сайжруулах;
- vi. Монгол улсыг гадаад оронд сурталчлах, аялал жуулчлалын салбарын өрсөлддөх чадварыг сайжруулах зэрэг болно.

БҮЛЭГ 4



4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү түүвэр судалгаагаар аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг эрэлт /гадаад жуулчид/, нийлүүлэлтийн /тур операторууд/ талаас судалж, улмаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх талаар бодлогын арга хэмжээний санал боловсруулахад дэмжлэг үзүүлэхээр зорьсон билээ.

1. Эрэлт талаас /гадаад жуулчид/

Судалгаанаас харахад гадаад жуулчдын дийлэнх нь Монгол улсад хийсэн аялалдаа сэтгэл хангалуун байсан бөгөөд дараах байдлаар дүгнэж болохоор байна. Үүнд:

- Монгол улсад зочлох гадаадын жуулчдын талаас дээш хувь нь 40-өөс дээш насныхан байна.
- Аяллын мэдээллийн дутмаг байдал нь Монгол улсад ирэхээс өмнөх хамгийн том бэрхшээл болж байна.
- Жуулчид дунджаар 13 хоногийг Монголд өнгөрүүлдэг бөгөөд нислэгийн тийзийн үнийг оролцуулан нийт 2,318 ам.доллар зарцуулдаг байна.
- Жуулчид аяллын үзвэр, үйлчилгээнд хамгийн бага зардлыг зарцуулдаг боловч өндөр сэтгэл ханамжтай байдаг.
- Олон улсын нислэгийн тийзийн үнэ бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа нь Монгол улсын хувьд өрсөлдөөний сул талыг бий болгож байна.
- Жуулчдад визний төлбөр, виз хүсэх явц хүндрэлтэй байна.
- Монгол улсад аялж байгаа гадаадын жуулчдад тулгардаг хамгийн хүндрэлтэй асуудал нь нийтийн бие засах газрын олдоч, ариун цэврийн асуудал байна.
- Интернет, утсан холбооны асуудалд аяллын зорилго, жуулчдын онцлогоос шалтгаалж харилцан адилгүй үнэлгээг өгсөн.
- Жуулчдын сэтгэл ханамжийн хувьд зам тээвэр, хоолны амт чанар, сонголт ба аюулгүй байдлыг онцолсон байна.
- Халаасны хулгай, таксины үйлчилгээ, зам тээврийн байдал жуулчдыг аюулгүй байдалдаа санаа зовниход хүргэж байна.

2. Нийлүүлэлт талаас /тур оператор/

Тур операторуудын хувьд аялал, жуулчлалын салбарт мэргэшсэн ажиллах хүчинг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулахад чиглэн ажиллах хэрэгтэй байгааг илэрхийлсэн бөгөөд дараах байдлаар дүгнэлээ. Үүнд:

- Аялал, жуулчлалын салбарын хүний нөөцийн бодлогыг сайжруулах нэн шаардлагатай байгааг харуулж байна.
- Удирдах ажилтнуудын хувьд 2 хүн тутмын нэг нь аялал жуулчлалын мэргэжилтэй бөгөөд 10 гаруй жилийн туршлагатай байна.
- Тур операторууд дунджаар 1,100 ам.долларын үнэтэй аяллын багцуудтай бөгөөд жилд 360 орчим гадаад жуулчдыг хүлээн авч байна.
- Тур операторуудын идэвхитэй үйл ажиллагаа явуулах хугацаа нь дунджаар 6 сар байдаг тул жуулчны бус улиралд ихэвчлэн дараа жилийн бэлтгэл ажил болон сул зогсолт хийдэг байна.
- Үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тур операторууд нь урт хугацааны (5-аас дээш жил) санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцлөөр авах хүсэлтэй байна.
- Тур операторуудын хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулахад голчлон (i) үйлчилгээний байгууллагын үйлчилгээний стандарт хангалтгүй, (ii) хүний нөөцийн хүрэлцээ, чадавхи сул, (iii) хууль эрх зүйн орчин, бодлогын тогтворгүй байдал зэрэг асуудлууд хамгийн том хүндрэл учруулдаг байна.
- Тур операторын үйл ажиллагаанд Төрийн бус байгууллагуудын үзүүлж буй дэмжлэг зонхилж байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

1. Хүний нөөцийг чадавхжуулж хөгжүүлэх чиглэлээр

1.1 Аялал жуулчлалын салбарын улирлын зогсолт нь тур оператор компаниуд ажилтнуудаа нийгмийн даатгалд хамруулахаас зайлсхийхэд хүргэж байна. Иймд аялал жуулчлалын салбарын хүний нөөцөд тохирох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

1.2 Аялал жуулчлалын салбарт ажиллаж буй аяллын хөтөч, үйлчилгээний ажилтнуудын туршлага, мэдлэг, ур чадварт суурилсан стандарт, зэрэгжилтийг бий болгох. Тус стандартын дагуу сургалт зохион байгуулж, мэргэжлийн зэрэг олгох;

1.3 Тур операторуудад үйл ажиллагаагаа тогтворжуулахын зэрэгцээ тэлэх боломжийн талаарх мэдээллийг өгөх, аяллын төрлөөр мэргэшүүлэх сургалтыг тогтмолжуулах, харилцан туршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх;

2. Шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр

2.1 Олон улсын нислэгийн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, тийзийн үнийг бууруулах арга хэмжээ авах. Дотоодын нислэгийн салбарт шударга өрсөлдөөнийг дэмжих, нислэгийн үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах боломжуудыг эрэлхийлэх, энэ салбарт амжилттай ажиллаж буй гадаадын орнуудаас туршлага судлах;

2.2 Гадаадын тур операторууд болон тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн бус этгээдүүд аяллын үйл ажиллагаа явуулж байгаад зохицуулалт хийх;

3. Гадаадын жуулчдыг татах, салбарын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр

3.1 Монгол улсын талаарх мэдээлэл, Монголд аялах зөвлөмжийг байршуулсан нээлттэй мэдээллийн сан байгуулах;

3.2 Аялал жуулчлалын үзэсгэлэн дэх Монгол улсын байрыг сайжруулах, илүү олон тур операторууд үзэсгэлэнд оролцох боломжийг нэмэгдүүлэх;

3.3 Онлайнаар виз авах боломжийг бий болгох, визгүй зорчих орнуудын тоог нэмэгдүүлэх;

3.4 Азийн зах зээлийн 55-аас дээш насны, ажлын амралтанд баригдахгүй жуулчид руу хандсан урт хугацаатай аяллын хөтөлбөр бий болгох;

3.5 Үзвэр, үйлчилгээний газруудын тоог нэмэгдүүлэх, тэдний үйл ажиллагааг дэмжих;

3.6 Улирлын зогсолтоос хамаарах татвар, хөнгөлөлтийн бодлого хэрэгжүүлэх;

3.7 Тур операторуудыг чадавхжуулах, орлогыг нэмэгдүүлэх инкубатор төсөл хэрэгжүүлэх;

4. Монгол дахь аяллын чанарыг сайжруулах чиглэлээр

4.1 Жуулчдын дайран өнгөрөх зогсолтын цэгүүдэд нийтийн бие засах газар байгуулах, тэдгээрийн бүрэн ажиллагааг хангах;

4.2 Дэд бүтцийн хөгжил, тэр дундаа авто замын засвар, замын хөдөлгөөний түгжрэлийн асуудлыг шийдвэрлэх;

4.3 Тур операторууд харилцаа холбооны компани, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах;

4.4 Жуулчны улиралд гадаадын жуулчдын аюулгүй байдлыг хамгаалах аюулгүй такси, халаасны хулгайгаас сэрэмжлүүлэх тэмдэг тэмдэглэгээ, идэвхтэй

цагдан сэргийлэх ажиллагаа, аялал жуулчлалын нийлүүлэгч байгууллагуудад анхаарал сэрэмжтэй байхыг анхааруулах, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах;

4.5 Үзвэр, үйлчилгээний байгууллагуудад үйлчилгээний чанарын стандарт шинэчлэн нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах;

4.6 Аялал жуулчлалын үйлчилгээ нийлүүлэгч байгууллагууд болох зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, үзвэр үйлчилгээ, нислэгийн компаниудын үйл ажиллагааний тогтвортой байдлыг хангах чиглэлд судалгаа явуулж, гол асуудлуудыг илрүүлэх;

Энэхүү судалгааны цар хүрээг өргөжүүлэх, дараа дараагийн жилд дахин явуулснаар өмнөх жилийн байдалтай харьцуулсан судалгаа явуулах боломжтой болох бөгөөд энэ нь бодлогын чиглэлд авсан арга хэмжээний үр дүнг харж, Монголын аялал жуулчлалын чиг хандлагыг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой юм.


ХАВСРАЛТ

№	Судалгаанд хамрагдсан байгууллагуудын нэр
1	Хаппи Сити Групп Ххк
2	Бирга Тур Ххк
3	Монголиан Экспедишнс Энд Турс Ххк
4	Монголиан Трэйкинг Ххк
5	Монголиан Вэйс Ххк
6	Хонгорын Элс Трэйвел Ххк
7	Ай Ланд Трэйвел Ххк
8	Хавай Тур Ххк
9	Дисковер Монголиа Трэйвел Ххк
10	Актив Адвентчер Турс Монгол Ххк
11	Мазаалай Эксплор Ххк
12	Говь Бээр Адвентур Турс Ххк
13	Аян Трэйвел Ххк
14	Атар Арт Трэйвел Ххк
15	Манжуурын Аялал Ххк
16	Бата Экспединшнс Ххк
17	Бүүжим Экспедишнс Ххк
18	Анчин Бүргэд Ххк
19	Бт Энд Тс Ххк
20	Дмд Монгол Ххк
21	Талын Бүүвэй Трэйвел Ххк
22	Талын Үнэг Ххк
23	Женко Тур Бюро Хк
24	Гоёо Трэйвел Ххк
25	Грийт Чингис Турс Энд Экспедишнс Ххк
26	Хис Монголиа Ххк
27	Ирис Турс Ххк
28	Жигүүр Ххк
29	Жуулчин Ххк
30	Нью Жуулчин Турс Ххк
31	Бил Арт Монголиа Ххк
32	Ар Монгол Трэйвел Ххк
33	Лоок Монголиа Ххк
34	Монгол Аялал Жуулчлал Ххк
35	Монтрэйлс Ххк
36	Номадс Турс Экспедишнс Ххк
37	Номад Планет Ххк
38	Аз Трэйвел Ххк
39	Адвентур Радер Ххк
40	Тахь Трэйвел Ххк
41	Хосе Тур Ххк
Эх сурвалж: Аялал жуулчлалын хөгжлийн төв	

№	Улс орны нэр	Судалгаанд хамрагдсан жуулчдын тоо
1	БНСУ	402
2	АНУ	173
3	Франц	135
4	Герман	128
5	Япон	108
6	БНХАУ	101
7	ОХУ	63
8	ИБИБНУ	54
9	Итали	39
10	Австрали	35
11	Испани	19
12	Канад	18
13	Швейцарь	17
14	Бельги	11
15	ӨАБНУ	10
16	Польш	10
17	Тайван	9
18	Австри	9
19	Недерланд	8
20	Энэтхэг	7
21	Грек	6
22	Финланд	5
23	Тайланд	5
24	Бусад	64
Нийт		1436

№	Судалгаа авсан байршил	Нийт
1	Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал	1301
2	Зочид буудлууд	159
	Novotel	47
	H Nine	25
	Springs	43
	Bayangol	44
3	Жуулчны баазууд	83
	Gobi Mirage camp	32
	Gobi Discovery camp	8
	Hustai camp	23
	Terelj Lodge	20
Нийт		1543

Судалгаанд хариулж буй байдал /Байршил: “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал/



Хамтран ажиллах тухай албан бичгүүд:

**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ХӨГЖЛИЙН ТӨВ**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо,
Цэнгэл ууны нөөц, Байгаль хамгаалах төв 204 тоот
Утас: 976-77779001
E-mail: <http://www.mto.mn/>

2019.08.19 № 1/61
талай - нм № -т

Хамтран ажиллах тухай


“Аялал жуулчлалын хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газар нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд аялал жуулчлалын менежмент, боловсон хүчинийг чадавхижуулах, сургалт зохион байгуулах, ижил төвшний байгууллагуудтай хамтран ажиллах үүрэгтэй байгуулагдсан болно.

2019 оны 07 сарын 17-ны өдөр “Аялал, жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд” сэдэвт судалгааны ажил хийхээр Монголбанк нь Судалгаа, статистикийн газар болон “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ 1219/927 тоот дугаартай хамтран гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус судалгааны үндсэн зорилго нь Монгол улсад ирж буй гадаадын жуулчдын сэтгэл ханамжийн түвшинг үнэлж, аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, Монгол улсын аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч ААН-үүдийн өнөөгийн байдал, тэдгээрийн үйл ажиллагаанд хамгийн ихээр тулгарч буй хүндрэл бэрхшээл, төрөөс баримталж буй бодлого, дэмжлэг хэр хүртээмжтэй байгааг тодорхойлж улмаар салбарын шийдвэр гаргах түвшинэе удирдлагуудад зөвлөмж хүргэх юм.

Иймд 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс 31-ийг хүртэл 13 хоногийн хугацаатай өглөө, оройн нислэгийн цагаар Чингис хаан олон улсын нисэх буудлын зорчигчдын явах олон улсын транзит танхим болон хамгаалалттай бүс /хилийн бүс/-д нэвтрэн орж судалгаа хийх шаардлагатай байгаа тул бидний ажлыг дэмжин хилийн бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгож өгөхийг хүсэж байна. 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн дотор хариу ирүүлж бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Та бидний хамтын ажиллагаа улам өргөжих болтугай.

Хүндэтгэсэн:
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.БАДРАХ

Хавсралт,.... хуудас

D:/2019/A4.doc

**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ХӨГЖЛИЙН ТӨВ**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо,
Цэнгэл ууны нөөц, Байгаль хамгаалах төв 204 тоот
Утас: 976-77779001
E-mail: <http://www.mto.mn/>

2019.08.05 № 1/54
талай - нм № -т

Хүсэлт гаргах тухай

“Аялал жуулчлалын хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газар нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд Монгол Улсыг гадаад улс оронд сурталчлах үндсэн чиг үүрэгтэй байгуулагдсан болно.

Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын хуваарь батлах, эрх шилжүүлэх тухай 2019 оны 01 дүгээр сарын 25-ны А/24 дугаар тушаал, Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлын хуваарийг шинэчлэн батлах, эрх шилжүүлэх тухай 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/314 тоот тушаалын дагуу шинээр ашиглалтад орох “Хөшигийн хөндий” олон улсын нисэх буудалд аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулах тухай санхүүжилтийн хуваарийг “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ-д эрх шилжүүлэн баталсан.

Шинээр ашиглалтад орох “Хөшигийн хөндий” олон улсын нисэх буудал нь 2020 онд ашиглалтад оруухоор болсон тул мэдээллийн төв байгуулах ажлыг одоогийн “Чингис хаан” олон улсын нисэх буудалд байгуулахаар төлөвлөж байна.

Олон улсын жуулчдын мэдээллийн төв нь гадаад, дотоодын жуулчид, иргэдэд тухайн хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, холбоо харилцааг зохицуулах, жуулчдад анхан шатны мэдээлэл олгох, цаашлаад аяллын төрөл үйлчилгээ, такси, автобус гэх мэт захиалгын үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй байдаг.

Иймд “Чингис хаан” олон улсын нисэх буудлын одоогийн байгаа мэдээллийн төвийн газрыг шинэчлэн илүү өргөжүүлэн, жуулчдад мэдээлэл өгөх, Монгол улсаа сурталчлах зорилготой байгаа тул бидэнтэй хамтран ажиллахыг хүсэж байна.

Мөн “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ нь 2020 онд ашиглалтад орох шинэ нисэх буудалд мэдээллийн төвөө нүүлгэн шилжүүлж үйл ажиллагааг тасралтгүй явуулах хүсэлтэй байгаа тул бидэнтэй цаашид хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бидний хамтын ажиллагаа улам өргөжих болтугай.

Хүндэтгэсэн:
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.БАДРАХ

D:/2019/A4.doc

00000076

Аялал, жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд		
№	Бодлого, хөтөлбөр	Дэвшүүлсэн зорилтууд
1.	Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх “Үндэсний хөгжлийн цогц бодлого”	- Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох, - Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, - Жуулчин тээвэрлэх болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, - Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэх, - Монголд ирэх жуулчдын тоог нэг саяд хүргэх, - Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх
2.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020	- Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх; - Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх; - Аялал жуулчлалын салбарын судалгаа, мэдээллийн системийг хөгжүүлэх, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх; - Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах; - Аялал жуулчлалын салбарын гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх; - Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх.
3.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2025	- Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах - Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, судалгаа, мэдээллийн системийг хөгжүүлэх, чанаржуулах - Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг дэмжих, Монгол улсыг гадаад, дотоодод сурталчлах чиглэлээр хөгжүүлэх